

“ЦУСНЫ ДОНОРЫН ДЭЛХИЙН ӨДӨР”-өөр ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

Улаанбаатар хот

2026.06.22

НЭГ. ”Цусны донорын Дэлхийн өдөр”-ийн бэлтгэл ажлыг хангах

Төвийн захирлын 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн А/33 дугаар тушаалаар Цусны донорын дэлхийн өдөр тэмдэглэн өнгөрүүлэх Ажлын хэсгийг 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж ажлын хэсгийн ахлагчаар Бодлого төлөвлөлтийн албаны Хууль тогтоомжийн асуудал хариуцсан мэргэжилтэн ажиллалаа.

Ажлын хэсэг 2026 оны Цусны донорын дэлхийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх захирлын 2026 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн удирдамж, арга хэмжээний төлөвлөгөө, шаардлагатай зардал болох 10.279.000 (арван сая хоёр зуун далан есөн мянга) төгрөгийн санхүүжилтийг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Монгол дахь суурин төлөөлөгчийн газарт хүсэлт тавьж шийдвэрлүүлсэн.

Аймаг, Нийслэлийн эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, нэгдсэн эмнэлгийн дарга, захирал нарт уг өдрийн арга хэмжээг харьяа нутаг дэвсгэртээ зохион байгуулж хамтран ажиллахыг хүссэн албан бичиг, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын сэдэв, удирдамж, зургийг орчуулгын хамт хүргүүлж, арга зүйгээр хангаж ажилласан. Ажлын хэсэг Цусны донорын дэлхийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх бэлтгэл ажлын төлөвлөгөөний дагуу бэлтгэл ажлыг хангаж, 6 сарын 14-ний өдрийн хүндэтгэлийн арга хэмжээний хөтөлбөрийг гарган чиглүүлж ажилласан. Уг арга хэмжээг Улаанбаатар хот төдийгүй 21 аймаг, үндэсний хэмжээнд зохион байгуулалт сайтай болж өнгөрлөө.

Дэлхийн эрүүл мэндийн удирдамж, холбогдох тушаал шийдвэр, мэдээллийг төвийн цахим хуудаст байршуулан ил тод нээлттэй байдлыг хангасан.

Баянгол дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газар, Монголын Улаан Загалмайн Нийгэмлэг, Улкер Монголиа байгууллага, Пролианс ХХК, Yes Mongolia, Мөнх Халдун Тэнгэр ХХК, Сүү ХК зэрэг 10-ад байгууллага хүмүүнлэгийн үйлсийг дэмжиж хамтран зохион байгуулав.

ХОЁР. “Цусны донорын Дэлхийн өдөр”-ийн Хүндэтгэлийн арга хэмжээ


2005 оны 5 сард болсон 58 дахь удаагийн Дэлхийн Эрүүл Мэндийн Чуулга уулзалтын үеэр сайн дурын, авлагагүй цусны доноруудыг идэвхжүүлэх, тэднийг дэмжих зорилтыг олон улсын эрүүл мэндийн байгууллагын удирдлагууд санал нэгтгэйгээр дэмжиж, WHA58.13 тогтоолоор жил бүрийн 6 дугаар сарын 14-ний өдрийг Цусны донорын Дэлхийн өдөр болгон тэмдэглэх шийдвэрийг гаргасан.

Монгол Улсын Цус сэлбэлт судлалын салбар энэхүү Цусны донорын Дэлхийн өдөр”-ийн хүндэтгэлийн арга хэмжээг Нийслэл, Улаанбаатар хот төдийгүй Аймаг

орон нутагт “Хүмүүнлэг сэтгэлээр цусаа өгч, амьдрал бэлэглэе!” уриа дор нэгэн зэрэг тэмдэглэн өнгөрүүлээ.

“Хүмүүнлэг сэтгэлээр цусаа өгч, амьдрал бэлэглэе!” уриа дор зохион байгуулагдаж буй энэ жилийн үйл ажиллагаа нь цус сэлбэлт шаардлагатай байгаа өвчтөнүүдэд чанартай, аюулгүй, хүртээмжтэй цус, цусан бүтээгдэхүүнээр хангах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд тогтмол хугацаанд цусаа хандивлах шаардлагатайг олон нийтэд таниулах, шинээр сайн дурын эгнээг өргөжүүлэн тэлэх, тогтмол доноруудад амьдрлын зөв дадал, хэвшилд чиглүүлсэн, сайн дурын авлаггүй доноруудыг хэвлэл олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчилах, алдаршуулан урамшуулах зорилготой байлаа.

Цус сэлбэлт судлалын үндэсний төвөөс Цусны донорын Дэлхийн өдөр”-ийн арга хэмжээг Эрүүл мэндийн яам, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Монголын Улаан Загалмайн Нийгэмлэг, Монголын донорын холбоо төрийн бус байгууллага, Баянгол дүүргийн ИТХ, Засаг даргын тамгын газартай хамтран 600 хүртэлх зочинд нэг дор үйлчилгээ үзүүлэх боломжтой Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт байрлах UB EVENT HALL-д зохион байгууллаа. Хүндэтгэлийн арга хэмжээг Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн захирал, Анагаах ухааны доктор Б.Нарантуяа нээж, мэндчилгээ дэвшүүллээ.





Уг арга хэмжээнд:

- Улсын их хурлын гишүүн, Ж.Чинбүрэн
- Улсын их хурлын гишүүн А.Ариунзаяа,
- Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр
- Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Монгол дахь суурин төлөөлөгч Хадагтай **Сокорро Эскаланте** Dr Socorro Escalante,
- Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын мэргэжилтэн М.Цолмон
- Монгол Улсын Улаан загалмайн нийгэмлэгийн Ерөнхий нарийн бичгийн дарга Н.Болормаа
- Монгол Улсын Улаан загалмайн нийгэмлэгийн орлогч дарга Т.Баярчимэг

- “Монголын донорын холбоо” Төрийн бус байгууллагын ерөнхийлөгч М.Сосорбарам нар мэндчилгээ дэвшүүлж баяр хүргэв.

Мөн тус өдрийн арга хэмжээг төв пейж хуудсаар шууд дамжуулалт хийж олон нийтэд ил тод, нээлттэй сурталчилан ажиллалаа. Мөн өдөр Азийн Цус Сэлбэлтийн Нийгэмлэг (AATM) Цусны донорын дэлхийн өдрийг (WBDD 2026) цахимаар зохион байгуулсан бөгөөд тус цахим арга хэмжээнд амжилттай оролцоо.

<https://us02web.zoom.us/j/82970014447?pwd=5kaVnRQE3O6panCRocWpg0QU1fGcb2>



Хүндэтгэлийн арга хэмжээнд:

- Монгол Улсын Улаан загалмайн нийгэмлэгийн Эрүүл мэнд, нийгмийн хамгаалалын газрын дарга О.Билгүн
- Монгол Улсын Улаан загалмайн нийгэмлэгийн Эрүүл мэнд, нийгмийн хамгаалалын газрын ахлах ажилтан А.Мөнхтуул
- Сүү ХК-ны их эмч Г.Баттулга
- Баянгол дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга П.Өлзийнаран
- HWPL Олон улсын байгууллагын Хуулийн хэлтсийн ажилтан Б.Ариунсанаа
- HWPL олон улсын байгууллагын Хуулийн хэлтсийн ажилтан Б.Мэндбаяр
- “Proliance” ХХК Эмнэлгийн бизнесийн газрын захирал Х.Армия
- “Proliance” ХХК Эмнэлгийн бизнесийн газрын борлуулалтын менежер Б.Билгүүн
- Yes Mongolia төрийн бус байгууллагын ерөнхий нарийн бичгийн дарга, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Э.Төрбаяр
- “Yes Mongolia” төрийн бус байгууллагын дэргэдэх цусны донорын клубын тэргүүн, “Мөнх Халдун Тэнгэр” ХХК ерөнхий захирал А.Эрдэнэсайхан
- “Мөнх Халдун Тэнгэр” ХХК гүйцэтгэх захирал Ж.Мягмардорж
- “Дээз глобал” ХХК-ийн ерөнхий менежер Б.Анхцэцэг
- Бурханы сүм Дэлхийн сайн мэдээний аварлын зар нийгэмлэгийн тэргүүн, Баянзүрх салбарын дарга Ким Юль Сан
- We Love U тэргүүн, Зайсан салбарын дарг Чой Ин Рюль
- Сүхбаатар салбарын дарга Б.Анхбаяр болон Хүндэт донор, сайн дурын ажилтан, улаан загалмайчид, Олон улсын байгууллагын төлөөлөл, хэвлэл мэдээллийн байгууллага, ивээн тэтгэгч байгууллага, тэдний төлөөлөл, Эрүүл мэндийн байгууллага болон салбар салбарын төлөөлөл, Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн эмч мэргэжилтэн, ажиллагсад, хүндэт зочид оролцов.



ГУРАВ. Цусны донорын дэлхийн өдөрт зориулан гаргасан урилга, баннер, сурталчилгааны материалууд

Цусны донорын дэлхийн өдөр-2026” -г тэмдэглэн өнгөрүүлэх төлөвлөгөөний дагуу Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан уриа, логог ашиглан Цусны донорын дэлхийн өдрийг Монгол Улсад тэмдэглэн өнгөрүүлэх цахим урилга, баннер, сурталчилгааны материалын эх бэлтгэлийг хийн, Цусны салбар төвүүдэд удирдамжийн хамт албан бичгээр хүргүүлж, үндэсний хэмжээнд сурталчлан ажилласан.

Цахим урилга:



УРИЛГА

Эрхэм хүндэт *Socorro Escalante* таныг
“Хүмүүнлэг сэтгэлээр  цусаа өгч, амьдрал бэлэглэе!”
уриан дор зохион байгуулагдах
“Цусны Донорын Дэлхийн Өдөр”-ийн
хүндэтгэлийн арга хэмжээнд хүрэлцэн ирэхийг урьж
байна.



Хөтөлбөр

Хэвээ: 2026 оны 06 дугаар сарын 14-ний өдөр 09:00-11:30 цаг
Хаяв: БГД, 25-р эмийн салгаас дээшээ өгсөөд UB EVENT HALL-д





УРИЛГА

Эрхэм хүндэт *Э.Батшугар* таныг
“Хүмүүнлэг сэтгэлээр  цусаа өгч, амьдрал бэлэглэе!”
уриан дор зохион байгуулагдах
“Цусны Донорын Дэлхийн Өдөр”-ийн
хүндэтгэлийн арга хэмжээнд хүрэлцэн ирэхийг урьж
байна.



Хөтөлбөр

Хэвээ: 2026 оны 06 дугаар сарын 14-ний өдөр 09:00-11:30 цаг
Хаяв: БГД, 25-р эмийн салгаас дээшээ өгсөөд UB EVENT HALL-д



Баннер:



ЦУСНЫ ДОНОРЫН ДЭЛХИЙН ӨДӨР

2026.06.14



Хүмүүнлэг сэтгэлээр
цусаа өгч, амьдрал бэлэглэе! 



БИДЭНТЭЙ НЭГДЭЭРЭЙ



Сурталчилгааны материал:



ДӨРӨВ. Шилдэгээр шалгарсан хамтран ажиллагч байгууллагууд:

Цус сэлбэлт судлалын үндэсний төвтэй хамтран Хүмүүнлэгийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож иргэний үүрэг, нийгмийн хариуцлагаа нэр төртэй биелүүлж бусдад сайн сайхан амьдралыг бэлэглэж, хамтран ажилладаг шилдэг байгууллагуудаа Цусны донорын Дэлхийн өдрийг тохиолдуулан алдаршуулж, талархал илэрхийлсэн. Үүнд:



**ХҮМҮҮНЛЭГИЙН ҮЙЛСИЙГ ДЭМЖИГЧ
БАЙГУУЛЛАГА**









Хүмүүнлэгийн үйлсийг дэмжигч шилдэг байгууллагууд цусны доноруудыг өлзийтсүүлэн урамсуулах үйл хэрэгт тогтвортой хамтран ажилладаг "Сүг" ХХК, Дээд тогбыл ХХК "ZAYA BLUEE", Проланс ХХК, YES MONGOLIA ТӨРИЙН БҮС БАЙГУУЛЛАГА, Мөнх Халдун Тынгор ХХК /Donor brand/, Хан-Уул дүүргийн Улаан Загалмайн хороог шалгаруулав.

**ЦУСНЫ ДОНОРЫН ҮЙЛСИЙГ СУРТАЛЧЛАГЧ
БАЙГУУЛЛАГА**





"Хүмүүнлэгийн үйлсийг сурталчлагч байгуулалт"-ыг 2023 оноос хойш цусны хандлагаа сайжруулж, дэлгэрүүлж, нийгэмд өргө урсгалыг түгээн, итгэл нийдвэр урам зоригийг бие биедээ бэлэнлэхийг уриалж ажилладаг HWPL Олон улсын төрийн бус байгуулалт. Баянзүрх дүүргийн Асан дэргэн тэмгэн газар, Монголын Банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо, We Love U, Бурханы сүм дэлхийн сайн мэдээний авралын арг нийгэмлэгийг тус тус шалгаруулав.

ЦУСНЫ ДОНОР ЭЛСҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА




"Шилдэг донор элсүүлэгч хамт олон"-оор цусны донор элсүүлэх, сурталчлах ажлыг үр дүнтэй явуулж, цус цутлуулах, сар бүрийн 3-ны Цусаа бэлэглэх өдрийн арга хэмжээг хамтран зохион байгуулдаг 62 удаагийн явуулаар 4700 нэгж цус цутлуулсан Монголын донорын холбоо, 23 удаа 1063 нэгж цус цутлуулсан Сонгинохайрхан дүүргийн Улаан загалмайн хороо, 17 удаагийн явуулаар 892 нэгж цус цутлуулсан Баянгол дүүргийн Улаан загалмайн хороог онцоллоо

ТАВ. Цусны донорын дэлхийн өдөр хүндэт донор болсон иргэдийн төлөөлөл

Сайн дурын авлагагүй цусны доноруудын хүмүүнлэг үйлсийг алдаршуулах, талархал илэрхийлэх, аюулгүй цус, цусан бүтээгдэхүүний хэрэгцээний талаарх олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой. Түүнчлэн энэхүү өдөр нь цусаа сайн дураараа, үнэ төлбөргүй өгч бусдын амь насыг аврах үйлсэд хувь нэмэр оруулж буй доноруудын нийгмийн үнэлэмжийг нэмэгдүүлэх, хүмүүнлэг ёс, харилцан туслалцах сэтгэлийг түгээн дэлгэрүүлэх онцгой ач холбогдолтой юм. Энэ өдөр Улаанбаатар хотын хэмжээнд 77 хүндэт донор шинээр төрлөө: Үүнд:



Топ донор Ц.Энхтөгс



Алтан донор С.Соддэлгэр



Мөнгөн донор М. Гэрэлчимэг



Хүрэл донор Ч. Хишигжаргал



Хүрэл донор С. Баяраа



Хүрэл донор З. Өсөхбөяр



Хамгийн залуу
хүндэт донор Б.Хүслэн



Гэр бүлийн донор С.Соддэлгэр, С.Баярмаа

Цусны донорын Дэлхийн өдрийг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар 120 буюу түүнээс дээш цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөн “Хүндэт донор” эрхэм хүмүүсийг “Шударга журам” медалиар шагналаа.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар “Шударга журам медаль”-аар
М.Баттогтох





Шинээр хүндэт донор болсон доноруудын төлөөлөл

ЗУРГАА. Цусны донорын тухай хуультай боллоо

Цусны донорын тухай хуулийг Монгол улсын их хурлаар батлуулах их үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулсан эрхмүүдэд Цусны донорын дэлхийн өдрөөр хүндэтгэл үзүүлж Талархал гардууллаа.





ДОЛОО. Цусны донорын дэлхийн өдрийг утсан сарын аяны хүрээнд

Цусны донорын дэлхийн өдрийн үйл ажиллагааны рийл бичлэг 11, алдаршуулах постер 5, төвийн үйл ажиллагаатай холбоотой 1 мэдээ бэлтгэн сошиал хуудас болон вэб сайтад оруулан ажилласан байна. Мөн төвийн сошиал хуудсаар шууд дамжуулалт хийж, Mongol HD, MYONTB, Eagle tv, MYONP-д шууд нэвтрүүлгийн зочдоор холбогдох албаны хүмүүсийг оролцууллаа.

Зочны цаг: 5-р сарын 22-нд Цусны донорын тухай хуулийг баталснаар цусны доноруудын нийгмийн баталгаа, хөнгөлөлтийг бие даасан хуулиар хамгаалах болсон. Та нэг удаа цуса...
Цааш үзэх

MNB-Өглөө Хөтөлбөр Жил бүрийн 6 дугаар сарын 14-ны өдрийг "Дэлхийн цусны донорын өдөр" болгон тэмдэглэдэг



“Цусны донорын дэлхийн өдөр”-ийг угтсан сарын аяны хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн 17-18 насны сурагчдыг төвийн үйл ажиллагаатай танилцуулах ажлын удирдамжийн хүрээнд цусны донорын талаарх мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх, ирээдүйн донорын эгнээнд бэлтгэх, нийгмийн хариуцлага, хүмүүнлэг оролцоог төлөвшүүлэх зорилгоор нас насны бүлэгт тохирсон арга хэмжээг 140 гаруй сурагчдад зохион байгуулж ажилласан байна.

2014 оноос эхлэн “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн хүрээнд жил бүр Нийслэлийн засаг даргын захирамжаар “Улаанбаатар Марафон 2026” зохион байгуулагдах бөгөөд энэхүү спортын арга хэмжээтэй уялдуулан Цусны донорын Дэлхийн өдрийг олон нийтэд сурталчилна.

Марафон нь мэргэжлийн тамирчдаас гадна сонирхогч гэр бүл, хүүхэд залуучууд зэрэг бүх насны хүмүүсийг нэг дор нэгтгэн, иргэдэд урам зоригтой, идэвхтэй эрүүл амьдралын хэв маягийг уриалдаг. Нийт 1500 гаруй стикер тараасан.



НАЙМ. Бусад

Цусны донорын дэлхийн өдөр 85 хүндэт донор 20 гаруй хамтран ажиллагч байгууллагууд шагнагдсан байна. Мөн арга хэмжээнд Хүндэт донор, сайн дурын ажилтан, улаан загалмайчид, Олон улсын байгууллагын төлөөлөл, хэвлэл мэдээллийн байгууллага, ивээн тэтгэгч байгууллага, тэдний төлөөлөл, Эрүүл мэндийн байгууллага болон салбар салбарын төлөөлөл, Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн эмч мэргэжилтэн, ажиллагсад, хүндэт зочид гээд нийт 380 гаруй хүмүүс уг арга хэмжээнд хамрагдсан байна.

Мөн Цэргийн дуу бүжгийн эрдэм чуулга бүрэлдэхүүнээрээ хүндэтгэл үзүүлэн хамтран ажилласан.





Тайлан бичсэн:

Хэвлэл мэдээлэл, хамтын ажиллагаа хариуцсан ажилтан

Ч.Урантүлхүүр

Хянасан:

Хууль тогтоомжийн асуудал хариуцсан мэргэжилтэн

П.Алтангэрэл